

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 21-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 21-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 21-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-11
<hr/>	
1. “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	3-11

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 21-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 04 дүгээр сарын 21-ний өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 28 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Жавхлан, Ч.Хүрэлбаатар;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Бат-Эрдэнэ, Ж.Ганбаатар, Х.Ганхуяг, О.Цогтгэрэл.

Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа оролцов.

Нэг. “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, мөн газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийг төлөөлөх эрх бүхий Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат, “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн компанийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Гантулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Ч.Ундрам, Ш.Адьяа, М.Оюунчимэг нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, мөн газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат нар хариулж, тайлбар хийв.

Ц.Цэрэнпунцаг: “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 1

Бүгд: 12

91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 21-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

Хуралдаан 32 минут үргэлжилж, 18 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 10 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 21-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 04 дүгээр сарын 21-ний
өдөр, Баасан гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
09 цаг 28 минут.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023
ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 21-
НИЙ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Цэрэнпунцаг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдээ танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанд Жамбалын Ганбаатар гишүүн өвчтэй байгаа. Болдын Жавхлан гишүүн гадаадад томилолттой. Чимэдийн Хүрэлбаатар гишүүн гадаадад томилолттой. Ингээд бусад гишүүд хүрэлцэн иржээ. Ингээд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, хуралдааны ирц 55.6%-тай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-д тогтоосон “онцгой дүгнэлтийн хугацааг сунгах тухай” асуудал.

ЗГ-ын 2023 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр УИХ-д саналаа ирүүлсэн. Ингээд хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-д тогтоосон “онцгой дүрмийн хугацааг сунгах тухай” асуудлыг хэлэлцэж эхэлье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар төслийн хэлэлцүүлгээ явуулах үед хуралдаан даргалагчаас дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93-ын 3 дахь хэсгийг үндэслэн төслийг Байнгын хороогоор дахин хэлэлцүүлэх горимын санал гаргаж дэмжигдсэн.

Ингээд ажлын хэсгийг танилцуулъя.

Жигжидийн Амарбаясгалан Монгол Улсын сайд, ЗГ-ын Хэрэг эрхлэх газрын дарга, Ганбат “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төлөөлөх эрх бүхий ЗГ-ын онцгой бүрэн эрхт төлөөлөгч, Б.Ганбат ЗГХЭГ-ын тэргүүн дэд дарга, Ч.Дондогмаа ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга, Түвшинжаргал “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Хууль, эрх зүйн газрын дарга, Гантулга тус компани Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга.

Ингээд тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх УИХ-ын гишүүд нэрсээ өгнө үү. Адьшаа гишүүнээр тасаллаа. Ингээд Баттөмөр гишүүн асуултаа асууя.

Б.Баттөмөр: Энэ дээр нөгөө төмөр замаа бичдэггүй юм уу, энэ мухар төмөр замуудаа яах юм. Энэ стандартад зөрчихсөн барьчихсан зөндөө олон асуудлууд байгаа шүү дээ. Нөгөө овоолго хийчихсэн, түүнийг яаж байгаа юм, тэр энэ тэр гээд нь бичдэггүй юм уу? Энэ бичсэн юман дотроо ороод холбогдоод явчхаж байгаа юм уу? Мэдээж Тавантолгойн цахилгаан станцын асуудал энд хамаагүй гэж үзэж байгаа байх, тийм ээ.

Ер нь асуудлууд байгаа шүү дээ. Та нар өөрсдөө юу гэж үзэж байгаа юм. Энэ

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 21-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

дээр орох барих юмнууд дутуу байгаа юм биш үү? Ийм асуулт байна.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгээс Баттөмөр гишүүний асуусан асуултад ажлын хэсгийн 1 номерын микрофоныг нээе. Нөгөө талдаа Ганбат дарга аа. 1 номер.

ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга Ганбат Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Энэ тогтоолын төслийг өчигдөр Эдийн засгийн байнгын хорооныхонтой нэлээн ажлын хэсгийнхэндээ ярьсан. Тэгэхээр саяын таны яриад байгаа стандарттай холбогдолтой асуудлыг энэ дээр тогтоолын төсөл дээр нэлээн дэлгэрэнгүй байдлаар тусгаж байгаа. Өөрөөр хэлбэл Эрдэнэс Тавантолгой компанийн үндсэн үйл ажиллагаанд нэгдүгээрт, Монгол Улсын яг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандартыг ягшигтал мөрдүүлэх ёстой гэдэг ийм асуудлыг тавьж байгаа. Хоёрдугаарт, олон улсын хэмжээнд яг энэ уул уурхайн компанид тавигддаг ямар нөхцөл шаардлага, стандарт тавигдах вэ. Тэр асуудлыг энэ дээр хангуулах ийм зайлиггүй шаардлага байгаа. Тэгэхээр тогтоолын төсөл дээр үүнтэй холбогдолтой заалтыг нэмэлтээр оруулж ирж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Баттөмөр гишүүн асуулт хариулт, хангалттай юу байна уу? Нэмэлт асуулт асууя.

Б.Баттөмөр: Яах вэ, олон улсын стандарт гээд юм байгаа л байх. Тэгэхдээ стандартгүй ухаад, стандартгүй ашиглаад, хулгай зэлгий нь явчихсан байгаа шүү дээ. Тэгээд энэ эрчим хүчний нүүрс чинь коксжих нүүрс чинь эрчим хүчний нүүрс гээд гараад явчхаж байгаа юм. Тэгэхээр энэ юмнуудаа та нар энэ лаборатори энэ тэртэй холбоотой асуудлууд, мухар төмөр замтай холбоотой асуудал, төмөр зам, цахилгаан станц энэ тэр нь үүнтэй холбоогүй тусдаа нөгөө яам, яам дээрээ явчихна гэж

үзэж байгаа юм уу, тийм үү? Тэгвэл тэгээд.

Ц.Цэрэнпунцаг: Ундрам гишүүн асуултаа асууя.

Ч.Ундрам: Энэ тогтоолын төсөлд байгаа 5 дугаарт байгаа, Монгол УИХ-ын 23 оны 8 дугаар тогтоолын 1 дүгээр заалтын хэрэгжилт гээд тэгсэн байна л даа. Тэгэхээр үүнийг нөгөө 1072 хувьцаатай холбоотой асуудал гэж ойлгож болох уу? Ер нь энэ 1072 хувьцааны асуудлыг бид нар яаралтай шийдмээр байгаа юм. Энэ хувьцаа олгогдсоноос хойш 90284 иргэн нас барсан байгаа. Энэ хүмүүсийн өв залгамжлах асуудлыг бид нар бас ярих ёстой. Үнэхээр шударгаар ярья гэвэл. Энэ чинь нийт 90.3 тэрбум төгрөгийн асуудал. Мөн 13365 хүн харьяатаас гарсан юм байна. Энэ хувьцаа олгогдсоноос хойш. Шинээр 900000 гаруй хүүхэд төрсөн байна. Энэ хүүхдүүдэд шинээр хувьцаа олгох юм уу, үгүй юу? Энэ нийт хувьцаа авсан хүмүүсээс 440000 иргэн өнөөдрийг болтол 1 ч төгрөгийн ногдол ашиг огт аваагүй байна. Тэгэхээр энэ 1072 хувьцаатай холбоотой асуудлуудыг цэгцлэх мөн цаашилаад компани маань ингээд ашигтай ажиллаад эхлэх юм бол ногдол ашиг тараах, тэгээд хамгийн гол нь 1072 хувьцаа чинь яг эдийн засгийн эргэлтэд орохгүй бол хувь хүний өмч гэж ерөөсөө харагдахгүй байна. Хүн өмчөө худалдаж, борлуулж, эдийн засгийн эргэлтэд оруулж болдог, өвлүүлж болдог байх ёстой. Гэтэл энэ Монголын ард иргэд 1072 хувьцаа гэдэг 1 бүртгэлтэй. Тэгээд 1 ЗГ-аас юу шийднэ вэ, түүнийх нь дагуу авбал аваад, авахгүй бол авахгүй гэдэг чинь хүний өмч гэсэн үг биш болчихоод байгаа юм. Тэгэхээр энэ 1072 хувьцааны асуудлыг заавал бид нар тэр хууль, эрх зүйнхээ хүрээнд зөв болгож шийдүүлэх ёстой юм. Хүнд хэрвээ өмч эзэмшүүлж байгаа юм бол эзэмшүүлсэн шиг эзэмшүүлэх ёстой. Тэгэхээр энэ асуудлыг энэ тогтоолын төсөлд оруулахгүй юм уу эсвэл энэ 5 дугаар заалтад багтаад явж байгаа юм уу гэсэн асуулт байна.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 21-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

Ц.Цэрэнпунцаг: Би эндээс ерөнхийд нь хариулчихъя. Дараа нь Амарбаясгалан дарга нэмээд та хариулаарай. Ер нь энэ чинь хэдэн сар 1 сард гарчихсан байна уу, 8 дугаар тогтоол байгаа шүү дээ. Энэ тогтоол дээр бүгдийг нь бид нар 1 бүрчлэн заагаад, энэ бүх асуудлуудыг оруулаад, үүрэг чиглэлээ өгчихсөн юм байгаа тийм. Тэгэхээр цаашаа бид нар энэ дээр болохоор зэрэг бид нар энэ тогтоолыг нь энэ гарах Их Хурлын тогтоолын төсөл дээр ер нь цаашидаа бас сар болгон бид нарт энэ явцынхаа талаар Их Хуралд мэдээлж байхаар бас үүрэг чиглэл өгч байгаа юм. Тэгэхээр энэ 8 дугаар тогтоолоор аль эрт өгчихсөн учраас давхиулаад байх шаардлагагүй ээ гэж үзэж байгаа юм.

Амарбаясгалан дарга та нэмж хариулах уу?

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ундрам гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын ЗГ-аас УИХ-ын 8 дугаар тогтоолын дагуу энэ 1072 хувьцаа эзэмшигчдийн асуудлыг 1 мөр шийдэх энэ асуудлыг судлаад, өнгөрсөн 7 хоногийн ЗГ-ын хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдын зүгээс тодорхой үүрэг чиглэл өгөгдсөн. Энд юу байна вэ гэхээр нэгдүгээрт, Монгол Улсын иргэн бүр энэ 1072 хувьцаа эзэмшигч болох ёстой. Тэгэхийн тулд 2012 оны 04 дүгээр сарын 11-нээс хойш төрсөн хүүхэд бүрд нь эхний ээлжид энэ хувьцааг эзэмшүүлэх 1072 хувьцаа эзэмшигч болох 1 дэх асуудал, хоёрдугаарт, энэ “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцаа бас нээлттэй хөрөнгийн биржээр арилжаалагдах боломжгүй анх гарсан хувьцаа. Яагаад гэхээр энэ том уул уурхайн компанийн хувьцаа 1 дор төвлөрөхөөс урьдчилан сэргийлэх, иргэн бүр энэ “Эрдэнэс Тавантолгой” компаниас ноогдол ашиг хүртдэг байх энэ боломжийг бүрдүүлэх зорилготой байсан учраас арилжаалах боломж өнөөдөртөө байхгүй. Ер нь цаашидаа ч бас арилжаалах боломжтой

хэлбэр лүү орох боломж их хомс юм байна лээ.

Зүгээр энэ дунд нэг 2, 3 асуудал үүсчээд байгаа юм. Яг өнөөдрийн байдлаар. ЗГ өргөн барихаас өмнө.

1 дүгээрт нь, энэ 2015 онд Сайханбилэгийн ЗГ байхдаа 1072 хувьцааг мөнгөжүүлэх ажлыг тодорхой түвшинд хийчихсэн. Оюутны сургалтын төлбөр, ахмадуудаас бас зарим 1072 хувьцааг нь шууд худалдаж авах хэлбэрээр хийчихсэн нь өөрөө цаашидаа бүх иргэн энэ хувьцаа эзэмшигч болоод явах нөхцөлийг бас доголдол үүсгээд байгаа, 1 асуудал нь болчихоод байна.

2 дугаарт, 1072 хувьцаа эзэмшигчид маань ноогдол ашигийг хангалттай хэмжээнд өнөөдрийг хүртэл хүртэж чадахгүй яваад байгаа 1 асуудал байна. Энэ нь өөрөө төрийн зүгээс шийдвэр гаргаад Тавантолгой ХК-ийн бүх орлогоор хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудыг төлөвлөж хийгээд ирсэнтэй холбогдоод өнөөдөр ноогдол ашигаа авч чадахгүй тохиолдлууд гарсан. 2020 онд 1 ноогдол ашиг өгсөн, 21, 22 онд ноогдол ашиг өгч чадаагүй өнөөдөр явж байна.

Тэгэхээр ЗГ-ын зүгээс энэ иргэн бүр хувьцаа эзэмшдэг байя. Цаашидаа энэ ноогдол ашигт иргэнд оногдож байгаа хувь энэ хөрөнгө оруулалтад огт зориулагддаггүй байя. Жил болгон ноогдол ашигийг тогтмол өгдөг байя гэсэн энэ шийдэл рүү ороод явж байгаа гэдгийг бас энэ ташрамд хэлмээр байна.

Өчигдөр бас УИХ дээр манай ажлын хэсгийнхэн хариулсан байгаа. Ер нь ноогдол ашигт ноогдож байгаа хувийг яаж олгох талаараа компанийн гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн түвшинд компанийн тухай хуулиараа асуудлаа шийдвэрлээд олгоод явдаг болъё, доголдол үүсгэдэггүй байя гэдэг энэ шийдэл рүүгээ явж байгаа гэдгийг хэлье.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 21-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

Тэгээд 1 үгээр хэлэх юм Монгол Улсад төрсөн иргэн “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцаа эзэмшигч болно, эргээд нас нөгчсөн тохиолдолд, Монгол Улсын иргэншилээс гарсан тохиолдолд энэ хувьцаа эзэмшигчийн эрх хаагддаг байхаар зохицуулалт хийх юм л гэж ингэж л бид төсөөлж явж байгаа юм.

Ц.Цэрэнпунцаг: Адьшаа гишүүн асуулт асууя.

Ш.Адьяа: Энэ онцгой дэглэмийг сунгах тухай энэ асуудал өнөөдөр УИХ дээр яригдаад бас янз бүрийн шүүмжлэл хэл амтай л байна. Тэгэхдээ үүнийг дэмжиж шийдэх ёстой байх. Өнөөдөр бид нар өчигдөр ч би УИХ-ын чуулган дээр энэ байр сууриа илэрхийлсэн. Хамгийн гол асуудал бол энэ экспортын асуудлыг дэмжиж, компанийн засаглалыг л сайжруулах ийм зорилгоор л энэ асуудлыг оруулж ирж байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр энд 2 асуудал байна л даа. Энэ “Эрдэнэс Тавантолгой”-н гүйцэтгэх эрх мэдлийг шинээр томилох асуудал энэ УИХ-ын тогтоолд яахаараа орж ирдэг юм. Түүнийг нь тэгээд журмаараа томилж болдоггүй юм уу, энэ тогтоол дээр чинь. Тэгээд л 1 компанийн захирал томилох асуудал хүртэл энэ УИХ-ын тогтоолоор шийдэгддэг энэ асуудал чинь хаашаа юу төвлөрөөд байна? Энэ УИХ-ын дарга Занданшатар гэдэг хүн өнөөдөр энэ ийм юмыг Байнгын хороогоороо оруулж ирж байгаад ямар дүгнэлт хийж байна? УИХ Өнөөдөр 1 ТӨК-ийн захирал томилох тухай тогтоол гаргаад явж байгаад энэ УИХ-ын Байнгын хорооны дарга нар энд ямар бодолтой байна. Цэрэнпунцаг даргаас би хариулт авъя.

2 дахь нь асуудал. Монгол Улсын стандарт, олон улсын стандарт шаардлага нэвтрүүлнэ гээд байна, олон улсын ямар шаардлага нэвтрүүлэх юм, энэ УИХ-ын тогтоолоор. Энэ чинь дотроо хийчхэж болдоггүй юм уу. Энэ УИХ-ын тогтоолыг боловсруулж байгаа энэ бичиг баримтын боловсруулалт манай

УИХ-ын дарга энэ тэр чинь их шаардлага тавьдаг юм шүү дээ. Хууль тогтоомжийн тухай хуульд ийм юм болоогүй байна, тийм юм чинь болохгүй байна гээд. Үгүй ээ, энэ боловсруулж байгаа энэ бүх хууль чинь энэ Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлж, энэ Байнгын хорооны тогтоолоо гаргадаггүй юм уу? Бид нарт л их сайхан шаардлага тавьдаг юм. Энэ 2 асуултад хариулт авъя.

Ц.Цэрэнпунцаг: Эхлээд би хариулчихъя. Тэгээд Амарбаясгалан сайд дараа нь та гүйцээгээд хариулаарай.

1-т, Адьяа гишүүний 2 асуултын эхний асуулт бол энэ онцгой дэглэмийг заавал сунгах асуудлыг бид нар Их Хурлаар оруулж ирж ингэж шийдвэр гаргах ямар шаардлагатай юм бэ гэж асууж байгаа юм байна. Энэ дээр нарийн ширийн асуудлуудыг нь цаашаа ЗГ, компанийнхан хэлнэ. Ерөнхийдөө бол энэ компани яагаад энэ БЭТ томилох хүртэл энэ онцгой дэглэм тогтоох ийм нөхцөл байдал үүссэн бэ гэдгийг бүх хүн мэдэж байгаа шүү дээ. Тэгээд энэ том нүсэр компани дээр энэ ажлыг цэгцэлж цаашидаа энэ компанийг хэвийн горимоороо тийм ээ, ингээд энэ үйл ажиллагаагаа явуулах, үүний удирдлагыг нь ажиллах хэвийн үйл ажиллагаа явуулах боломжийг нь олгох, дээрээс нь ялангуяа энэ компанитай холбоотой энэ олон асуудлуудыг, ялангуяа аудит, аудитын дүгнэлт гаргуулахаас авхуулаад, энэ олон ажлууд гарцаа байхгүй цаг хугацаа шаардсан ийм ажил учраас энэ 6 сарын хугацаа богинохон байна. Энд амжсангүй ээ гэж. Тэгэхээр энэ гарцаа байхгүй онцгой дэглэмийг бид нар энэ Их Хурлын тогтоолоор, Их Хурлын шийдвэрээр онцгой дэглэмээ энэ тогтоож БЭТ томилох эрхийг нь энэ ЗГ-т олгосон юм. Тэгэхээр зэрэг энэ хугацаа нь энэ 4 сарын 26-нд дуусаж байгаа учраас дахиж энэ зайлшгүй ийм нөхцөл байдал үүссэн ийм учраас бид нар энэ онцгой дэглэмийг цааш нь үргэлжлүүлэх энэ эрхийг нь ЗГ-т өгч байгаа юм.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 21-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

Тэгэхээр энэ бодит гарч ирж байгаа нөхцөл байдал бол энэ цаг хугацаа шаардсан ажил юм. Ингээд энэ ажил руу ороод энэ гардаад энэ ажлыг хийж байгаа. Өнөөдөр үр дүнг нь бүгд л магтаад л яриад байгаа шүү дээ. Ямар хэмжээний борлуулалт хийв, ямар хэмжээний татвар төлж байна, ямар хэмжээний валютын нөөцийг нэмэхэд ямар хэмжээний хувь нэмэр оруулж байна гэдгийг яриад байгаа юм. Тэгэхээр үүнийг бид нар энэ хийж байгаа энэ ажлаа гүйцээж хийхэд нь гарцаагүй цаг хугацаа шаардлагатай байгаа учраас бид нар энэ хугацаа 6 сарын хугацаа дуусахаас нь өмнө энэ сунгах эрхийг нь өгч, Их Хурал шийдвэр гаргахгүй бол болохгүй ийм нөхцөл байдал үүссэн.

2 дахь нь, энэ онцгой дэглэм тогтоох болсон энэ хууль зүйн үндэслэл нь бид нар энэ шүүмжлүүлээд байгаа энэ хууль нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хуулиас Монгол Улсын Үндсэн хуулийг бүрнээ дагаж мөрдөхөд шилжих тухай гээд энэ хуулиар олгогдсон энэ 92 оны хууль байна уу, энэ хууль дээр энэ хуулиар байна шүү дээ 5 дугаар зүйл дээр нь байна. Хууль тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн шинэчлэх гэдэг дээр би танд уншаад өгье. Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болох хүртэл дагаж мөрдөж ирсэн бүх хуулийг мөнхүү Үндсэн хуульд харшлахгүй бол цаашид хүчин төгөлдөр дагаж мөрдөнө өө гээд. Тэгээд энэ хуулийн үндэслэл байгаа учраас бид нар энэ хуулиа, тэр бол энэ компанийн, энэ ЗГ-ын өөрийнх нь ажил байхгүй юу. Бид нар бол, ийм учраас Амарбаясгалан сайд та гүйцээж хариулъя.

Д.Амарбаясгалан: Адьяаа гишүүний асуултад хариулъя. Адьяаа гишүүний асуултын хариултыг Адьяаа гишүүн ээ, яах вэ, энэ гүйцэтгэх удирдлагыг нээлттэй сонгон шалгаруулж томилох үүргийг энэ тогтоолд Монгол Улсын Ерөнхий сайдад үүрэг болгож орж ирж байгаа заалтын талаар асууж байна гэж ойлголоо. Мэдээж УИХ энэ

тогтоолдоо ямар заалт оруулах нь УИХ-ын бүрэн эрхийн асуудал байх. ЗГ-ын зүгээс энэ “Эрдэнэс Тавантолгой” компанийн гүйцэтгэх удирдлагыг улс төрөөс хараат бус, олон улсын жишигт нийцсэн загвар, стандартад нийцүүлэх ийм л зорилгыг агуулж байгаа. Зүгээр яах вэ энэ өнгөрсөн 6 сарын хугацаанд олон улсад нээлттэй сонгон шалгаруулалт зарлая, олон улсын менежментийн багийг оруулъя, энэ “Эрдэнэс Тавантолгой”-г түвшин ахиулъя гэдэг ийм зорилгыг агуулж ажилласан боловч өнгөрсөн хугацаанд яасан бэ гэхээр 1 дүгээрт, олон улсын стандартын дагуу аудитын дүгнэлтийг гаргуулж авах энэ боломж 1 дүгээрт бүрдсэнгүй.

2 дугаарт, “Эрдэнэс Тавантолгой” компани өнөөдөр 3.5 орчим их наяд төгрөгийн өртэй байгаа байдал нь ахиад олон улсын менежментийн баг орж ирж ажиллах сонирхлыг төрүүлэхгүй байна.

3 дугаарт, ер нь нүүрстэй холбоотой энэ төсөлд олон улсын хөгжилтэй улс орны менежментийн том групп компаниуд орж ирж ажиллах сонирхол бас их буурчихсан байдаг юм байна. Тэгэхээр бидэнд зайлшгүй хугацаа шаардлагатай болж байна. Ирэх 6 сарын хугацаанд 1 дүгээрт энэ хууль, эрх зүйн орчныг сайжруулъя. 2 дугаарт компанийн гүйцэтгэх удирдлагыг томилох үйл явц, процесс, цаашидаа үйл ажиллагаа нь аль 1 түвшинээс үл хамааралтай хараат бус байх нөхцөлийг нь Компанийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр зохицуулж хийе ээ гэсэн энэ зорилгыг бас давхар агуулж байгаа гэдгийг хэлье.

Ц.Цэрэнпунцаг: Адьяаа гишүүн нэмэлт асуулт асууя.

Ш.Адьяаа: Ойлголоо. Тэгээд Цэрэнпунцаг дарга ч тийм хариулах сонирхолгүй л байгаа юм байна. Амарбаясгалан даргаас хариултаа авчихлаа гэж ойлголоо. Чуулган дээр би нэмж сайн тайлбар авъя. Ер нь л 1

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 21-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

болохгүй байна даа, Цэрэнпунцаг дарга аа.

Ц.Цэрэнпунцаг: Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

М.Оюунчимэг: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. Цэрэнпунцаг дарга аа. Сая энэ онцгой дэглэм тогтоосноос хойших хугацаанд “Эрдэнэс Тавантолгой” компани компанийн түүхэнд хамгийн өндөр ашиг олж 1.3 их наяд буюу 37%-ийн цэвэр ашигтай ажилласан гээд ийм сайхан үзүүлэлттэй байгаа. Тэгээд энэ үзүүлэлтэд хүн бүхэн үнэхээр талархаж байна. Тийм учраас өчигдөр би ч бас асуусан.

1 дүгээрт, нэгэнт л үүрэг чиглэл ЗГ өгсөн бол 4 сарын 28-ны өдөр хуралдах ТУЗ-аараа энэ ноогдол ашгаа хуваарилахтай холбоотой асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх хэрэгтэй байна гэдгийг би бас ТУЗ-ийн дарга Ганбат дарга болон Хэрэг эрхлэх газрын дарга энд анхаараасай гэж хүсмээр байна. Ер нь УИХ-ын Байнгын хороо тогтоолоор ЗГ-т үүрэг өгсөн бол түүнийг заавал биелүүлэх үүрэгтэй. Энэ 8 дугаар тогтоолын 2-ын 1 дээр нь байна л даа. Энэ “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Монгол Улсын иргэдэд эзэмшүүлэх 12 оны 4 сарын 11-ний өдрөөс хойш төрсөн Монгол Улсын иргэдэд шинээр хувьцаа эзэмшүүлэх асуудлыг судалж гэж байна. Энэ асуудлыг судлаад асуудлыг шийдвэрлэж байгаа талаар сая Амарбаясгалан дарга ярьж байна.

2 дахь зүйл нь, 2023 оны 1 дүгээр улиралд багтаан УИХ-д танилцуулах гэж чиглэл энэ тогтоолоор өгсөн байна. Одоо 23 оны 1 дүгээр улирал дуусчихсан байгаа шүү дээ. Тэгэхээр 1 дүгээр улирал үүгээр тогтоол өгсөн л түүнийг танилцуулах ёстой. Одоогоор ашгийн түвшин ийм байна, бид тэдэнд хуралдаад үүнийгээ ингэнэ гээд энэ тогтоолын дагуу ЗГ болон үүрэг чиглэлийг танилцуулах үүрэгтэй. Тийм учраас та нар энэ дээр хариулт өгөхгүй 1 дүгээр улиралдаа багтааж

танилцуулах бололцоо байгаагүй юу. Эсвэл судалж, аудитын дүгнэлт хийж, тодорхой дүгнэлтэд хүрч байж өнөөдөр нэгмөсөн онцгой дэглэм тогтоох тухай асуудлыг сунгах үедээ танилцуулчихъя гээд ЗГ өөрийнхөө түвшинд үүнийг шийдчихсэн юм уу?

Тэгээд Байнгын хороо ч гэсэн яг тогтоолоо цаг хугацаанд нь шаардаж биелүүлж байх хэрэгтэй байна л даа. Үүнтэй дагуу 1 зүйл хэлэхэд энэ бас ч гэж Эрдэнэс Тавантолгой экспортын энэ энэ нааштай үзүүлэлтүүд гарсны үр дүнд долларын хани 3500-аас доошоо буурчихсан, 3480, ер дээр ирчихсэн байна. Одоо бусад улс оронд долларын хани дагаад юмны үнэ хани өсчихсөн тохиолдолд буцаад долларын хани буурсан бол юмны үнэ хани үүнийгээ дагаад буурах ёстой. Одоо ингээд буурахгүй тогтчихсон. Тэгээд л энэ ноогдол ашиг хуваарилах тухай асуудал яривал дахиад л үнэ хани өсчихнө, инфляцад нөлөөлчихнө гээд эсрэгээрээ тайлбарлаад байдаг. Гэтэл яг үнэнийг хэлэхэд юм, үнэ ханиийн өсөлтөд иргэдийн амьдрал маш хэцүү байна шүү дээ. Уулзалт болгонд юу ярьж байна гэхээр карматай л холбоотой, түрийвчтэй холбоотой асуудлыг бүгд ярьж байна. Том, жижиггүй. Тэгээд энэ дээр бас бид нарт жоохон ч гэсэн ноогдол ашгийг нь бэлэн мөнгөөр биш юм гэхэд бусад хувилбараар ч юм уу, хуваарилах асуудлыг 1-д шийдэх хэрэгтэй байна.

2-т нь, энэ хэрэглэгчдийн эрх ашиг ч юм уу хамгаалдаг байгууллага байна уу, үгүй юу Амарбаясгалан дарга аа. Долларын хани буурчихлаа, бензиний үнэ хани тогтвортой байна. Тэгвэл буцаагаад үнээ, ханшаа өсгөсөн газрууд жоохон ч гэсэн энэ долларын ханины бууралттай хамаараад үнээ яагаад бууруулахгүй тэгээд л тогтчих юм. Тэгээд буцаад долларын хани өсвөл дахиад доллар өсчихлөө гээд нэмчихдэг. Гэтэл иргэдийн авч байгаа гар дээрээ авч байгаа цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж ямар байгаа билээ. Тэгээд ер нь 1 тийм

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 21-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

зохицуулалт юм уу, энэ нөгөө ШӨХТГ нь юм уу, эсвэл энэ хэрэглэгчийн төлөө өөр газар байна уу, мэргэжлийн хяналтууд байна уу? Бас иймэрхүү энэ үнэ ханшийн зохицуулалт инфляцыг дагаад хөдөлгөдөг болгомоор байна л даа. Тэгээд энэ зүйл дээр анхаарахгүй бол бид нар энд хууль дүрэм гаргаад байдаг, амьдрал дээр эсрэгээрээ болоод байна шүү дээ. Сая тэр Алтан тариаг жишээлбэл торгоход гурилынхаа үнэ дээр асуудлыг би оруулаад л шингээнэ гээд л ярьж байсан тийм ээ. Тэгээд энэ үнэхээр тэр нь зөв байсан юм уу, буруу байсан юм уу? Одоо бас 1 ард иргэдээ бодож энэ асуудалд хандах хэрэгтэй байна.

Тэгээд энэ саяын ноогдол ашигтай холбоотой асуудлаар яг тодорхой хариулт авахыг хүсэж байна. УИХ-ын тогтоолын биелэлтийг ингээд танилцуулах хугацаа нь өнгөрчихсөн байгаагийн шалтгааныг бас асуумаар байна?

Ц.Цэрэнпунцаг: Оюунчимэг гишүүний асуулттай холбоотой бас Байнгын хороон дээр хийж байгаа, явуулж байгаа юмаа бас хэлье. Энэ таны яг нөгөө саяын тэр тогтоол дээр зааж өгсөн, хэрэгжүүлэх ёстой ажлуудыг бид нар араас нь яаж шахаж, ажиллаж байгаа юм бэ гэж. Тэгэхээр энэ бид нарын энэ өнөөдрийн хэлэлцэж байгаа энэ тогтоолын төслийн 2 дугаар заалтын 5 дээр та хараарай. Энэ 5 дээр бид нар бүр энэ 8 дугаар тогтоол бий шүү дээ. Үүний 1 дүгээр заалтын хэрэгжилтийг биелэлтийг сар бүр гээд байгаа шүү УИХ-д танилцуул гээд ингээд, танилцуулах гээд оруулчихсан байгаа. Бид нар энэ сая улирлаар гээд заачихсан учраас бүр сар бүр гээд ингээд шахаж биелэлтийг нь Их Хурал дээр сонсъё оо гэсэн энэ дээр шахаж ингэж хатууруулж оруулж байгаа шүү.

Ингээд ажлын хэсгийн 2 номер. Амарбаясгалан сайд хариулъя.

Д.Амарбаясгалан: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. 4 сарын 28-ны өдөр “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал болохоор товлон зарлагдсан байгаа. Үүнээс өмнө “Эрдэнэс Тавантолгой” компанийн 2022 оны санхүүгийн тайланд аудит хийгдэж дуусах ийм зорилготойгоор ажиллаж байна. Тэгэхээр энэ аудит хийгдээд, ноогдол ашгаа тодорхой болгоод, тэгээд хувьцаа эзэмшигчдийн хурлаар энэ асуудал орж байж эцэслэн шийдвэрлэгдэхээр явж байна гэсэн үг. Үндсэндээ, мэдээж УИХ-ын тогтоолоор 1 дүгээр улиралдаа багтаа гэж шийдвэр гарч, 3Г-т үүрэг болж ирсэн. Яг энэ дагуу 3Г бас үйл ажиллагаагаа явуулж байгаа. Компанийн тухай хууль болон тэр ээлжит нөгөө хувьцаа эзэмшигчдийн хурлын цаг хугацаатай уялдаад энэ асуудал өнөөдөр ийм байдлаар орж ирж байна гэдгийг бас тайлбарлаж танилцуулъя.

Ер нь “Эрдэнэс Тавантолгой” компанийн ноогдол ашигийг илүү нэмүү өртөг шингэсэн байх нь зүйтэй гэдэг бодлогоор урьд өмнө нь ажиллаж ирсэн байна лээ. Тухайлбал иргэдэд оногддог ноогдол хувийг “Эрдэнэс Тавантолгой” компаниас хэрэгжүүлж байгаа томоохон төслүүдэд шингээх ажил өнгөрсөн хугацаанд хэд хэдэн удаа хийгдсэн. Харамсалтай нь өнөөдөр Гашиун сухайт төмөр замаас өгсүүлээд томоохон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлууд бүрэн дуусаагүй. Эргэлтэд ороогүй, эргээд иргэдэд ашиг хувь хүртэх тэр боломжийг байхгүй болгоод байгаа энэ 1 тал байна. Гэхдээ “Эрдэнэс Тавантолгой” үүнийг урьд өмнөх шийдвэр зөв, буруу гэж ярьж орхих гэхээсээ илүүтэйгээр богино хугацаанд дуусгаж, үр дүнг нь улс орныхоо хувьд ч тэр, ард иргэдийн хувьд ч тэр гаргаж авахын зор зорилгыг агуулж ажиллаж байгаа гэдгийг бас танд хэлмээр байна.

2 дугаарт, таны сая хөндсөнчлөн энэ валютын ханшийн өөрчлөлтөд “Эрдэнэс Тавантолгой”-н оруулж байгаа

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 21-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

хувь нэмэр их өндөр байна. Өнөөдрийн байдлаар ДНБ 1 хүнд оногдох хэмжээ нь 5033 долларт болтлоо өслөө. Энэ 2023 он гараад Монгол Улсын түүхэнд анх удаагаа 5000 доллараос дээш 1 хүнд оногдох ДНБ-тэй болж хувирч байна.

2 дугаарт, валютын ханшийн нөөц нэмэгдүүлэх чиглэл дээр “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ч хувь нэмэр үндсэндээ хувилаад ярих юм бол 50 орчим хувьтайгаар нөлөө үзүүлж байгаа. Тэгээд өнөөдөр 3.7 орчим тэрбум долларын нөөцтэй болсон байгаа нь үүний үр дүн. Цаашидаа ЗГ-ын зүгээс богино хугацаанд үүнийг 4 тэрбумд хүргэх энэ зорилтыг тавьж байна. Түүнээс дээш гарч байж энэ валютын ханш нэлээн буурч орж ирэх буюу төгрөгийн ханш чангарна гэж ингэж гэж тооцож байгаа.

Тантай санал 1 байгаа зүйл нь валютын ханшийн өөрчлөлттэй холбоотойгоор бараа бүтээгдэхүүний үнэ өсдөг, эргээд буурах энэ нөхцөл хангалттай түвшинд байж чадахгүй байгаад байна. Тэгэхээр ЗГ-ын зүгээс ер нь энэ монополын эсрэг хууль, эрх зүйн орчныг чангатгах, үүнтэй холбоотой үйл ажиллагааг тогтмол явуулдаг байгууллагыг бий болгох туйлын зорилго байна гэж ингэж үзэж байна. Зүгээр нэгхэн жишээ хэлэхэд саяхан ЗГ-ын хурал дээр бас танилцуулга хийгдсэн баруун аймгуудын онгоцны нислэгтэй холбоотой асуудал хөндөгдөж байгаа юм. Жишээ нь Баян-Өлгий аймаг руу өнөөдөр Аэро Монголиа компанийн Embraer 145 гэдэг онгоц нисээд ирэх зардал нь 36, 7000000 төгрөгийн зардал гарч байгаа юм. Тэгэхдээ бүтэн нисээд ирэхдээ чартер нислэг үйлдээд олж байгаа орлого нь 72-78 сая төгрөгийг олж байна. Тэгээд энэ нугарсан ийм ашиг олдог бизнес дэлхийд ер нь хаана байдаг юм. Монголд л байгаад байгаа байхгүй юу. Бүх салбар дээр ийм болчихоод байна. Гурилын салбар дээр чинь ийм байна, бусад төрлийн салбар дээр ийм болчихоод байгаа учраас зас ЗГ-ын монополын эсрэг хатуу тэмцэх шаардлага үүссэн гэж үзэж байгаа. Өнөөдөр хий хоосон хөөргөдөл үүсгэж

байгаа нөхцөлүүд дандаа ийм байдалтай. Гэтэл бид нар тооцоо хийгээд үзэхэд байна шүү дээ, 10%-ийн ашигийн төлөө Агаарын тээвэр хүлээн авах боломжтой 9 аймагт 7 хоногт 3 удаа нисэхэд нэгхэн онгоцоор бүрэн хангах боломжтой. Энэ тооцоолол хийгдчихсэн, харамсалтай нь хувийн хэвилийнхэн бол татаас өг өө, бидэнд нэмэлт орлого хэрэгтэй байна. ЗГ татаас өгөхгүй бид хуваарьт нислэг үйлдэхгүй ээ гээд ингээд суучихдаг. Тэгсэн мөртөө “Эрдэнэс ... /минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Ингээд Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93-ын 1 дэх хэсгийг үндэслэн Байнгын хорооноос боловсруулсан “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” УИХ-ын тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

“Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93-ын 1, 93-ын 2 дахь хэсэг, 1991 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр батлагдсан ЗГ-т эрх олгох тухай хуулийн 3 дугаар зүйл, Монгол УИХ-ын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5-ын 1 дэх хэсгийг үндэслэн Монгол УИХ-аас тогтоох нь:

1. Улс орны эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, гадаадын валютын орох урсгал, нөөцийг нэмэгдүүлэн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК тогтоосон Онцгой дэглэмийн хугацааг 6 сараар сунгасугай.

2. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын ЗГ Л.Оюун-Эрдэнэд даалгасугай.

1. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан онцгой дэглэмийн хугацаанд компанийн удирдлага, зохион

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 21-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

байгуулалтын оновчтой бүтцийг бий болгох, засаглалыг сайжруулж, гүйцэтгэх удирдлагыг ил тод, нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилох,

2. Компанийн үйл ажиллагаанд олон улсын нэр хүндтэй хөндлөнгийн аудитын компаниар нэн даруй аудит хийлгэх,

3. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үндсэн үйл ажиллагаанд олон улсын болон Монгол Улсын стандарт, шаардлагыг хангуулах,

4. Онцгой дэглэмийн хугацаанд яллагдах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагааг жигдрүүлж, цаашид хэвийн тогтвортой ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх.

5. Монгол УИХ-ын 2023 оны 8 дугаар тогтоолын 1 дүгээр заалтын хэрэгжилтийг хангах талаар шуурхай арга хэмжээ авч, тус тогтоолын биелэлтийн явцыг сар бүр УИХ-д танилцуулах.

3 дугаар заалт. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо Ц.Цэрэнпунцаг, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо Т.Энхтүвшинд үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолыг 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын төсөл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

“Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” УИХ-ын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 91.7% нь дэмжиж, санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд УИХ-ын гишүүн Т.Энхтүвшин танилцуулна.

10.00 цаг

Байнгын хорооны хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Хуралдаанд оролцсон гишүүддээ баярлалаа.

Баярлалаа.

Дууны бичлэгээс буулгасан:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ